

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨМА-2022/15/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр	8
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан / мянган төгрөгөөр/.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	12
3.5.3 Авлага.....	12
3.5.4 Урьдчилгаа	13
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	13
3.5.6 Бараа материал	13
3.5.7 Үндсэн хөрөнгө	14
3.5.8 Өр төлбөр	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж.....	18
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНТС	Орон нутгийн тусгай сан
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.БАТБОЛД ТАНАА

2022.03.24 № 266
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,446,443.2	8,295,932.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,091,448.5	2,496,782.1
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	931,227.1	1,637,007.6
34	УРЬДЧИЛГАА	6,144.9	6,144.9
35	БАРАА МАТЕРИАЛ	3,468,468.8	3,283,723.2
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	949,153.9	872,274.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	189,935,402.5	180,026,446.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж	0.0	0.0
37200	Үнэт цаас	0.0	0.0
37300	Урт хугацаат зээл	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	189,935,402.5	180,026,446.0
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	183,841,612.9	173,931,388.7
39300	Биет бус хөрөнгө	6,093,789.6	6,095,057.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	197,381,845.7	188,322,378.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	948,758.0	393,412.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	948,758.0	393,412.7
41100	Богино хугацаат үнэт цаас	0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.0	0.0
41300	Өглөг	65,169.8	29,763.5
41400	Урьдчилж орсон орлого	883,588.2	363,649.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	196,433,087.6	187,928,965.9
51	Засгийн газрын хувь оролцоо	196,433,087.6	187,928,965.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	40,330,993.4	40,330,993.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	768,388.0	768,388.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0.0	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн	148,721,325.4	140,217,713.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,612,380.9	6,611,871.5
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	0.0
51600	Нөөцийн сан	0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо	0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	197,381,845.7	188,322,378.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	56,919,082.5	32,155,192.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,404,673.9	542,208.2
110	Орлогын албан татвар	1,073,269.7	177,562.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,073,269.7	177,562.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	5,062.0	8,816.2
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	326,342.2	355,829.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,984,223.0	15,409,842.7
120	Нийтлэг татварын бус орлого	22,984,223.0	15,029,841.7
121	Хөрөнгийн орлого	0.0	380,001.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
124	Зээлийн орлого	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,530,185.6	16,203,141.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	52,802,230.8	39,501,501.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,802,230.8	39,501,501.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,464,063.8	38,587,200.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,324,279.9	12,544,143.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,525,853.8	1,746,279.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,084,966.6	1,166,352.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,246,859.7	1,440,455.3
2105	Нормативт зардал	546,374.2	2,020,917.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	173,235.6	304,464.1
2107	Томилот, зочны зардал	4,719.0	5,626.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,382,313.9	1,496,633.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,175,461.0	17,862,328.9
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,338,167.0	914,300.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,116,851.6	-7,346,308.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,468,328.5	1,085,386.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,648,523.1	-8,431,694.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	37,556,276.6	21,737,794.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,404,673.9	542,208.2
110	Орлогын албан татвар	1,073,269.7	177,562.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,073,269.7	177,562.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	5,062.0	8,816.2
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	326,342.2	355,829.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	273,610.2	280,634.6
1181	Газрын төлбөр	46,712.8	72,542.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,019.2	2,652.2
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,601,417.1	4,955,250.0
120	Нийтлэг татварын бус орлого	3,601,417.1	4,575,249.0
121	Хөрөнгийн орлого	0.0	380,001.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,550,185.6	16,240,335.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,760,856.0	20,685,657.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,760,856.0	20,685,657.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,382,256.8	19,741,823.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,578,562.9	12,559,519.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,550,565.9	1,737,117.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,073,494.5	1,174,115.9
2104	Хангамж, бараа материалын зардал	471,925.2	596,037.0
2105	Нормативт зардал	483,545.8	530,095.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	161,848.4	313,753.6
2107	Томилот, зочны зардал	4,719.0	5,626.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,155,235.3	1,208,750.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,902,359.8	1,616,808.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,378,599.2	943,834.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,795,420.6	1,052,136.6

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,913,941.1	646,803.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,913,941.1	646,803.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,913,941.1	646,803.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,913,941.1	-646,803.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	0.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-118,520.5	405,333.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,209,969.0	2,091,448.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,091,448.5	2,496,782.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,541,744.4	0.0	194,541,744.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	242,820.1	0.0	242,820.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	194,784,564.5	0.0	194,784,564.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,648,523.1	0.0	1,648,523.1
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,433,087.6	0.0	196,433,087.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	196,433,087.6	0.0	196,433,087.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-72,427.2	0.0	-72,427.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,360,660.4	0.0	196,360,660.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0

18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-8,431,694.5	0.0	-8,431,694.5
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	187,928,965.9	0.0	187,928,965.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,000,988.7	17,964,212.6
2	УРСГАЛ ЗАРДАЛ	18,925,070.6	17,424,290.2
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,686,714.2	17,222,861.8
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,886,362.2	11,713,466.9
5	Үндсэн цалин	8,033,466.7	7,943,307.9
6	Нэмэгдэл	3,107,870.7	3,049,039.7
7	Унаа хоолны хөнгөлөлт	100,920.0	90,219.4
8	Урамшуулал	644,104.8	630,899.9
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,680,402.9	1,638,992.0
10	Тэтгэврийн даатгал	1,156,560.0	1,138,417.1
11	Тэтгэмжийн даатгал	125,879.8	122,732.8
12	ҮОМШӨ-ний даатгал	120,602.4	115,375.9
13	Ажилгүйдлийн даатгал	26,503.9	24,049.5
14	Эрүүл мэндийн даатгал	250,856.8	238,416.8
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,468,427.5	1,162,706.5
16	Гэрэл, цахилгаан	200,315.0	116,472.3
17	Түлш, халаалт	1,010,653.0	850,150.6
18	Цэвэр, бохир ус	257,459.5	196,083.6
19	Хангамж, бараа материалын зардал	515,090.0	471,227.1
20	Бичиг хэрэг	42,544.1	35,375.8
21	Тээвэр, шатахуун	241,804.9	230,468.8
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	53,366.6	50,066.5
23	Ном, хэвлэл	4,582.7	2,568.7
24	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,748.5	12,685.0
25	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	160,043.2	140,062.3
26	Нормативт зардал	305,339.1	188,038.2
27	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,310.5	8,194.5
28	Хоол, хүнс	264,078.6	146,929.1
29	Нормын хувцас, зөөлөн эдлэл	32,950.0	32,914.7
30	Эд хогшил, урсгал засварын зардал	320,653.2	302,379.0
31	Багаж, техник, хэрэгсэл	45,357.0	36,521.9
32	Урсгал засвар	275,296.2	265,857.1
33	Томилолт, зочны зардал	7,000.0	4,892.0
34	Дотоод албан томилолт	7,000.0	4,892.0
35	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,473,669.7	1,028,663.7
36	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,473,669.7	1,028,663.7
37	Бараа үйлчилгээний бусад зардал	1,029,769.6	712,496.4
38	Бараа үйлчилгээний бусад зардал	923,513.3	639,207.9
39	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	106,256.3	73,288.5
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	238,356.4	201,428.4

41	Бусад урсгал шилжүүлэг	238,356.4	201,428.4
42	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,326.6	109,869.9
43	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,516.4	23,516.3
44	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,513.4	68,042.1
45	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,075,918.1	539,922.4
46	Бусад хөрөнгө	1,075,918.1	539,922.4
47	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,000,988.7	18,089,480.7
48	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,832,700.3	11,554,749.6
49	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	11,264,325.1	10,986,374.4
50	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	568,375.2	568,375.2
51	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,265,395.9	6,268,073.1
52	Орон нутгийн төсвөөс	6,265,395.9	6,268,073.1
53	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,902,892.5	266,658.0
54	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.0	266,658.0
55	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,442,892.5	-
56	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	150,523.3
57	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	275,791.3
58	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	11,526.0	11,739.0
59	БАЙГУУЛЛАГЫН ТОО	27.0	27.0
60	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,019.5	1,015.5
61	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	9,460.0	9,681.0
62	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	7,413.0	7,349.0
63	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	2,047.0	2,332.0
64	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,019.5	1,015.5

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан / мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,005,318.9
2	УРСГАЛ ЗАРДАЛ		986,286.0
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		616,891.3
5	Үндсэн цалин		930.8
6	Нэмэгдэл		169.9
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		66.9
8	Тэтгэврийн даатгал		66.9
9	Хангамж, бараа материалын зардал		46,234.6
10	Бичиг хэрэг		4,864.5
11	Тээвэр, шатахуун		3,616.0
12	Ном, хэвлэл		8,687.8
13	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		29,066.3
14	Нормативт зардал		5,097.2
15	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,450.0
16	Хоол, хүнс		3,647.2
17	Эд хогшил, урсгал засварын зардал		67,366.7

18	Багаж, техник, хэрэгсэл		37,851.1
19	Тавилга		605.0
20	Урсгал засвар		28,910.6
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		167,686.4
22	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		166,436.4
23	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,250.0
24	Бараа үйлчилгээний бусад зардал		329,338.9
25	Бараа үйлчилгээний бусад зардал		301,348.3
26	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		27,990.6
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		369,394.7
28	Бусад урсгал шилжүүлэг		338,711.1
29	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		12,526.8
30	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		326,184.3
31	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		30,683.6
32	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		30,683.6
33	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		19,032.9
34	Дотоод эх үүсвэрээр		19,032.9
35	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		19,032.9
36	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,005,318.9
37	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,005,318.9
38	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		731,164.8
39	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		87,516.8
40	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		186,637.3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбогдсон зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Шижирболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 124 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Даланзадгад сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар аймагтаа манлайлагч Дэвшилтэт- Даланзадгад хотыг хөгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангах, хамтран хөгжих, төрийн үйлчилгээг гэр бүлд хүргэх, сумын ард иргэдийн тасралтгүй сурч хөгжих боломжоор хангах, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, дэмжих, сургалтын чанарыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаал
- “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал
- “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол
- “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд боловсруулан аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албанаас 2021 онд Даланзадгад сумын ЗДТГ, ИТХ, Захирагчийн ажлын алба, орон нутгийн тусгай сангууд, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хяналт шалгалт хийж, шалгалтаар нийт 180.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 9.4 сая төгрөгийг төсвийн орлогод, 1.4 сая төгрөгийг тухайн байгууллагад төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 170.0 сая төгрөгийн албан шаардлага өгч ажилласан байна. Актын төлбөр, албан шаардлагыг барагдуулах арга хэмжээг бүрэн авч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 39,535.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 395.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 276.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,091.4 сая, эцсийн үлдэгдэл 2,496.7 сая төгрөг болж, 405.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	134.5	685.7	551.2	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	134.5	685.7	551.2	100

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 2,332.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 17.7 сая төгрөг арилжааны банкны дансанд, 145.4 сая төгрөг барьцаа сангийн дансанд тус тус байршиж байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 931.2 сая, эцсийн үлдэгдэл 1,635.1 сая төгрөг болж 703.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	15.3	16.1	0.8
Төлбөртэй үйлчилгээний авлага			-
Татаас, санхүүжилтийн авлага	-	185.5	185.5
Дансны авлага ТӨҮГ	15.0	10.2	-4.8
Зээлийн хүүгийн авлага	3.0	11.6	8.6
Байгууллагаас авах авлага	46.3	501.9	455.6
Хувь хүмүүсээс авах авлага	851.4	909.6	58.2
Дүн	931.2	1635.1	703.9

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 703.9 сая төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-аас авах даатгалын санхүүжилт, сум хөгжлийн сангийн зээлийн авлагатай холбоотой байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 6.1 сая, эцсийн үлдэгдэл 6.1 сая төгрөг байна.

Хүснэгт № Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал			
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа	6.1	6.1	-
Томилолтын урьдчилгаа			
Дүн	6.1	6.1	-

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 3,468.4 сая, эцсийн үлдэгдэл 3,283.7 сая төгрөг болж, 184.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	113.2	155.2	42.0
Эм боох материал	60.2	69.8	9.6
Бэлэн бүтээгдэхүүн	7.5	4.4	-3.1
Бичиг хэргийн материал	40.9	25.4	-15.5
Аж ахуйн материал	865.1	919.5	54.4
Сэлбэг хэрэгсэл	0.3	14.1	13.8
Шатах тослох материал	16.3	16.2	-0.1
Барилгын засварын материал	6.4	7.5	1.1
Хүнсний материал	17.4	33.1	15.7
Бусад хангамжийн материал	2340.7	2037.7	-303
Дүн	3468.4	3283.7	-184.7

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны түүхий эд материал, хангамжийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулах шалтгаанаар нөөцөлсөн. Үүнд: Төсөвт байгууллагууд 2,947.1 сая, орон нутгийн өмчит байгууллагууд 336.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 242,657.7 сая, эцсийн үлдэгдэл 247,700.6 сая төгрөг болж 5042.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	45441.1	48167.9	2726.8
Тээврийн хэрэгсэл	3304.5	3428.9	124.4
Машин тоног төхөөрөмж	3719.8	3564.3	-155.5
Тавилга эд хогшил	2791.3	2748.8	-42.5
Зам гүүрний барилга байгууламж	140141.8	141519.5	1377.7
Дуусаагүй барилга байгууламж	5.1	-	-5.1
Бусад үндсэн хөрөнгө	40785.3	41844.2	1058.9
Түүх соёлын дурсгалт зүйл	8.3	8.3	-
Программ хангамж	66.8	58.0	-8.8
Бусад биет бус хөрөнгө	6064.4	6064.4	-
Номын фонд	329.3	296.3	-33
Дүн	242,657.7	247,700.6	5,042.9

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 106.8 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 274.8 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 6,979.9 сая, дахин үнэлгээний нэмэгдлээр 167.1 сая, нийт 7,528.8 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн, харин балансаас балансад шилжүүлсэн 240.5 сая, акталсан 2,245.3 сая, нийт 2,485.8 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 948.7 сая, эцсийн үлдэгдэл 393.4 сая төгрөг болж, 555.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	65.2	23.0	-42.2	64
Байгууллагад төлөх өглөг	63.6	0.8	-62.8	99
Татварын өглөг /ТӨҮГ/	1.5	8.5	7.0	5
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		9.0	9.0	100
Дансны өглөг /ТӨҮГ/		4.7	4.7	100
<i>Урьдчилж орсон орлогын дүн</i>	883.5	363.6	-519.9	59
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	638.7	145.4	-493.3	77
Бусад урьдчилж орсон орлого	244.8	218.2	-26.6	11
Нийт дүн	948.7	393.4	-555.3	58.5

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд төсөл сангийн 145.4 сая төгрөг, ОНӨААТҮГ, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны 247,9 сая, харьяа төсвийн байгууллагуудын 0.1 сая төгрөгийн өглөг тус тус байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 196,433.1 сая, эцсийн үлдэгдэл 187,927.1 сая төгрөг болж 8,506.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	40330.9	40330.9	-	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	768.4	768.4	-	-
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	148721.4	140215.9	- 8505.5	0.05
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6612.4	6611.9	-0,5	-
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	196,433.1	187,927.1	8,506.0	0.05

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,506.0 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн буурснаас шалтгаалжээ. Мөн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 6,611.9 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлэгдсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Даланзадгад сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 3/2 дугаар тогтоолд зааснаар сумын Засаг дарга тайлант онд 2,839.1 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,609.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 127.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төсвийн орлогын		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Урсгал орлого	2839.1	3609.8	770.7	127.1
Татварын орлого	546.0	740.0	194.0	135.5
Татварын бус орлого	2293.1	2869.8	576.7	125.1

Эх сурвалж: Даланзадгад сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 770.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь аймгийн Татварын газар, Мэргэжлийн хяналтын газрын хүү торгуулийн орлого, иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого тооцсон төлөвлөгөөнөөс давж орон нутгийн төсөвт төвлөрсөнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус сумын ИТХ-ын 2020 оны 2/8 дугаар тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,703.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 17,703.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар тогтоолоор тодотгол хийж 1201.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн орлого, зарлагыг 18,905.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 18,905.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,829.3 сая төгрөгийг урсгал зардалд, 1,075.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 4,889.5 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 10.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагаа, 1,442.8 сая төгрөгийг урд оны үлдэгдэл орлогоос санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 4,889.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 13.1 сая төгрөг бүрдүүлж, гүйцэтгэлийг 31.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 17,424.9 сая төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь төсвийн хэмнэлттэй холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлээр Сургууль цэцэрлэг ажиллаагүйгээс хоол хүнсний зардал, төсвийн зарим зардлын зарцуулах эрхийг хязгаарласнаар томилолт, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардлууд хэмнэгдэж дутуу зарцуулсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 1204.5 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 10 төсөл арга хэмжээнд 572.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 375.8 сая төгрөгийн санхүүжилт гэрээний дагуу олгогдож, 4 нэр төрлийн ажлын гүйцэтгэл дуусаагүй тул он дамжин хэрэгжихээр 2022 оны төсөвт суугдсан байна.

Мөн сумын төсвийн хөрөнгө оруулалтын 15 төсөл, арга хэмжээнд 503.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 164.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 5 төсөл арга хэмжээ бүрэн хийгдэж дуусаагүй он дамжин хийгдэхээр дараа оны төсөв суугдаж, нэг нэр төрлийн ажлыг хийхээргүй болсон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 731.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 87.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 186.6 сая, нийт 1,005.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: 974.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 30.6 сая төгрөгийг болон аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахалтай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж улс, аймаг болон орон нутгийн төсөв, нөөц хөрөнгө, урсгал төсвөөс 2768.4 сая төгрөгийн өртөг бүхий ариутгалын бодис, хамгаалах хувцас, хэрэглэл, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардал гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг данс бүртгэлд тусгаж ажилласан ч барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, эд хогшлын чанар, хэрэгжилтийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн мэдээллийг цаг хугацаанд нь оруулсан хэдий ч, хуулийн хугацаа хоцроон оруулах, мэдээлэлд засвар хийхэд анхааран ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын харьяа байгууллага болох сумын ЗДТГ, ИТХ-ын 2021 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгээгүй байна.

Даланзадгад сумын Засаг дарга нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан бөгөөд өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад дараах байдалтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжээгүй үлдэгдэл		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	60.1	1	60.1			
Төлбөрийн акт							
Зөвлөмж	3	557.0	3	557.0			
Нийт дүн	4	617.1	4	617.1			

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг Засаг даргын 2021 оны 05 сарын 24-ны өдрийн 327 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй зөв төлөвлөх, сум хөгжүүлэх сангийн зээл төлөөгүй иргэдийг олон нийтэд мэдээлэх, зээлийн төлөлтийг хугацаанд төлүүлэхэд анхаарах, хяналт хийх шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,157.7 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 450.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 707.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илрээгүй болно.

4.2 Албан шаардлага

Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад 33 иргэнтэй холбоотой хугацаа хэтрэлтэй 450.0 сая төгрөгийн зээл байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.3.2 " сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг олон нийтэд мэдээлж зээлийг эргэн төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн талаар

Илрүүлэлт 2: Сумын орлого тайлант онд 707.7 сая төгрөгөөр давж биелсэн ба давсан орлогыг зарим нэр төрлөөр нь ангилбал үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 80.0 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 15.2 сая төгрөгөөр, шууд бус орлого 39.4 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 299.0 сая төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлого 186.9 сая төгрөгөөр тус тус давсан байгаа нь орлогыг бодитой төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид орлогын төлөвлөгөөг дараа жилийн үйл явдалтай уялдуулан бодитой төлөвлөж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	2	1157.7					1	450.0	1	707.7